

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДЭГЭЭР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ

№ 77 (2381)

1974 оны 10 дугаар сарын 14

ДАВАА

УРГАЦЫН ТАЛБАЙГААС

Архустын ТАА 10 дугаар сарын 8-ны байдлаар бүх талбайн ургацын 69,1 хувийг хурааж энэ жилийн төлөвлөгөөг 111,3 хувиар биелүүлэв.

Ургац хураалтын ажилд БНМАУ-ын аварга комбайнч Г. Батсүх, Б. Цэрэндорж, Т. Эрдэнээ, ТАА-н 1973 оны аварга комбайнч Доржсүрэн нар өдөр бүрийн нормоо 130—150, Норовсамбуу, Амарбаясгалан, С. Загдгарав, С. Пүрэв, Даржаа, Сайлов, Гарамгай-баатар нар өдрийн нормоо 120—130, автын жолооч Санжаа, Бямбаа, Чойдорж, Пүрэвжид нар өдөрт гүйцэтгэх тонн км-ийг 110—120 хувиар тус тус биелүүлэв.

Х. БЯМБАСҮРЭН

ЭРХЭМ ДЭЭД ЗОЧНОО ИХ АМЖИЛТААР УГТЪЯ

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Засгийн газрын урилгаар ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, «Улс түмний хоорондын энх тайвныг бэхжүүлэхийн төлөө олон улсын Лениний шагналт Л. И. Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид, МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн баяр ёслолд оролцохоор энэ оны 11 дүгээр сарын сүүлчээр манай эх оронд айлчлан ирэх гэж байгаа баярт мэдээг ард түмнийхээ нэг адил тус аймгийн хөдөлмөрчид, коммунистууд туйлын баяр бахдалтай хүлээн авч, Зөвлөлдүүдийн орны эрхэм дээд элч төлөөлөгчдийг хөдөлмөрийн шинэ их амжилтаар угтах аа сэтгэл догдлон илэрхийлж байна.

Л. И. Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид, 1966 онд манай оронд найрсгаар айлчлан ирж, манай хоёр ард түмний удаан жилийн зузаан найрамдлын түүхийг улам шинэ үйл явдлаар баяжуулж, Монгол—Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааны түүхэнд шинэ үе шат болсон билээ.

В. И. Ленин, Д. Сүхбаатар нарын үндэс суурийг нь тавьсан тус хоёр орны элгэн халуун найрамдлыг улам бэхжүүлэн хөгжүүлэхэд нөхөр Л. И. Брежнев үлэмжийн их гавьяа байгуулсныг манай ард түмэн ямагт өндрөөр үнэлж, улмаар даан дэлхийд бат бэх энх тайван байдал тогтооход үнэлэхүй их хүчин чармайлт тавьж, нааштай сайхан алхамууд хийж байгаа явдалд чин сэтгэлээсээ хүндэтгэн талархаж байдаг юм.

Монгол—Зөвлөлтийн ард түмний жинхэнэ зүрх сэтгэл, ариун цусаар гагнагдан бэхжиж 50 гаруй жилийн түүхэн замнал туулсан манай хоёр ард түмний ах дүүгийн найрамдал тал бүрийн үр бүтээлт хамтын ажиллагаа бол социалист интернационализмын бодит биелэл, улс түмний харилцааны нэн гайхамшигт үлгэр дуурналад, шинэ нийгмийн байгуулалтын түүхэн их ололт мөн.

Монголын ард түмэн бүр анхнаасаа Октябрийн орны ард түмэнтэй нөхөрлөж, феодалын нийгмээс капитализмыг алгасан, социализм байгуулах замд баттай орсноо хоёр орны найрамдлынхаа түүхэн үр дүн гэж зүй ёсоор бахархдаг юм. Иймээс Монголын ард түмэн уламжлалт найрамдлаа ямагт хайрлан хүндэтгэж, улам бататган бэхжүүлж бийдэг билээ. Одоо ид эхлээд байгаа уламжлалт найрамдлын 23 дахь сарын ажил Монгол—Зөвлөлтийн ард түмний найрамдлыг улам бэхжүүлэн хөгжүүлэхэд том алхам болж, коммунизмын орны өгөөж баян туршлагаас улам шаргуу суралцах их боломжийг бүрдүүлнэ. Найрамдлын сарын энэ өдрүүдэд тус аймгийн хөдөлмөрчид коммунизмын орны баялаг туршлагаас улам шаргуу суралцах болно. ЗХУ-ын сэтгэл харамгүй их тусламж манай уудам эх орны хаа ч хүртээмжтэй өгөөмөр их билээ. Зөвхөн тус аймагт олон нэгдэл, САА-нууд ЗХУ-ын хүч хөрөнгөөр тохижиж, Зөвлөлтийн олон мэргэжилтнүүд манай социалист байгуулалтад туслаж, монгол нөхөддөө ихийг сургаж байна.

Тус аймгийн ажилчин, малчин, хөдөлмөрийн сэтгэлтнүүд эрхэм дээд зочноо угтаж 1974 оны төлөвлөгөөний үлдэж байгаа зорилтыг хугацаанаас нь өмнө биелүүлэх элэрхийлж, уралдаанд нэмэлт үүрэг амлалт авах хөдөлгөөн өрнүүлж байгааг тэмдэглэхэд бахтай байна. Энэ бол манай аймгийн хөдөлмөрчид, коммунизмын орны эрхэм дээд элч төлөөлөгчдийг МАХН-ын XVI их хурлын түүхт шийдвэр, улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх V таван жилийн төлөвлөгөөний 4 дэх жил-1974 оны бүх ард түмний социалист уралдааны жилийн ажилдаа улам давуу амжилт гаргасан дүнгээр угтах өндөр сэтгэгдэл урам зоригтой ажиллаж байгаагийн илэрхийлэл мөн.

Аймгийн аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1974 оны эхний 3 улирлын төлөвлөгөөний биелэлтийн тухай Статистикийн товчооны мэдээлэл 1974-10-10

Манай аймгийн нийт хөдөлмөрчид МАХН-ын XVI их хурал, бүгд хурлуудын түүхэн шийдвэрийг хэрэгжүүлж, МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг хөдөлмөрийн өндөр амжилтаар угтах уриан дор бүх ард түмний социалист уралдааныг өрнүүлж ажилласны үр дүнд аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1974 оны эхний 3 улирлын төлөвлөгөөт зорилтуудыг амжилттай биелүүлж байна.

Нэг. Ходоо аж ахуй

Аймгийн хэмжээгээр 9 дүгээр сарын 30-ны байдлаар төлөвлөх зохих хээлгэгч малын 93,1 хувь буюу 558,3 мянга нь төлөж 561,2 мянган төл гарсны 96,7 хувь буюу 542,8 мянга нь бойжиж байна. Аймгийн хэмжээгээр 38,3 мянган малын багтаамжтай 95 хашаа барьж жилийн төлөвлөгөөний 79,8 хувийг, орон нутгийн хүчээр уурхайн худаг 22-ыг гаргаж жилийн төлөвлөгөөний 78,5 хувийг, 97,8 мянган тонн өвс бэлтгэж төлөвлөгөөг 102,2 хувиар биелүүлээд байна.

Хоёр. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн газруудын нийт бүтээгдэхүүн гаргах төлөвлөгөө 113,4 хувиар биелэгдэж төлөвлөгөөнөөс 1,2 с а я төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлээд байна. Үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг үзүүлбэл (хувиар)

	Төлөвлөгөөний биелэлт	Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан
Хүнсний үйлдвэр	123,0	97,2
Хэвлэх үйлдвэр	112,3	111,3
НААУ-ний газар	111,7	111,1
Ойн аж ахуйн модны үйлдвэр	110,4	83,0
Архустын ТАА	84,1	198,0
Эрдэнэсантайн ТАА	90,7	2 да
Баянцогтын тэжээлийн үйлдвэр	115,7	2,7 да
Угтаалын тэжээлийн	69,0	109,4

НААУ-ний газар гутал, төмөр эдлэл үйлдвэрлэх төлөвлөгөөг 17,5—21,5 хувиар, ойн аж ахуйн модны үйлдвэр зүсмэл материал, гэрийн тооно, хаалга, парт үйлдвэрлэх төлөвлөгөөг 4,9—37,5 хувиар, Хүнсний үйлдвэр архи, гоймон үйлдвэрлэх төлөвлөгөөг 8,6—27,0 хувиар, Хэвлэх үйлдвэр ном товхимол үйлдвэрлэх төлөвлөгөөг 15,3 хувиар тасалдууллаа.

Гурав. Их барилга

САА, ХАА-н нэгдлүүд аж ахуйн аргаар 3472,1 мянган төгрөгийн барилга

угсралтын ажил гүйцэтгэж жилийн төлөвлөгөөний 75,8 хувийг биелүүллээ. Барилга угсралтын ажлын төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг үзүүлбэл:

	Төлөвлөгөөний биелэлт	Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал
Барилга угсралтын	108,9	116,4
Замын анги	2,5 да	132,2

Усны аж ахуй удирдах газар өрөмд мөл худаг 17-г, уурхайн худаг 58-ыг гаргаж 2,9 сая төгрөгийн ажил гүйцэтгэлээ.

Дөрөв. Тээвэр, холбоо

Авто тээврийн 13 дугаар бааз 27,8 мянган тонн ачаа тээж 4084,3 мянган тонн км-ийн ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс ачаа эргэлт 37,9 мянган тонн км-ээр нэмэгдэв.

Тээвэр, холбооны байгууллагуудын төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг үзүүлбэл: (хувиар)

	Төлөвлөгөөний биелэлт	Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал
Тээсэн ачаа	92,6	79,0
Ачаа эргэлт	106,8	110,2
Зорчигчдын тоо	3,7 да	173,5
Зорчигчид эргэлт	151,0	107,4
ТУ газрын орлого	112,8	81,3
Харилцаа холбооны орлого	111,4	113,8

Тав. Худалдаа бэлтгэл

Жижиглэн худалдаалах бараа гүйлгээ 62,7 сая төгрөг болж төлөвлөгөө 100,9 хувиар биелэгдэв.

Жижиглэн худалдаалах бараа гүйлгээний төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг байгууллагуудаар үзүүлбэл: (хувиар)

	Төлөвлөгөөний биелэлт	Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал
ХБУ газрын бараа гүйлгээ	100,4	102,9
Соёлын хэлтсийн номын гүйлгээ	75,5	72,0
Хэвлэлийн гүйлгээ	109,2	98,6
Эмийн гүйлгээ	105,9	106,6

(Төгсгөл нь II нүүрт)

[illegible]

МАЛ ЕСГӨХ УЛСЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ БИЕЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ!

Саяхан аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас нийт сум-нэгдэл, САА, үйлдвэр, аж ахуйн газрын дарга эрхлэгчдийн шуурхай зөвлөгөөн хийлгэв.

Зөвлөлгөөнд «Аймгийн мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлэх одоогийн боломж цаашдын зорилтын тухай» аймгийн Ардын хянан шалгах хорооны дарга Р. Чимэдцэрэн «Мал аж ахуйн өвлийн бэлтгэл ажлын явцын тухай» аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны ХАА эрхэлсэн орлогч дарга М. Нямаа нар сонсгол та вив. Зөвлөлгөөнд тавьсан сонсгол, мэдээлэл, үг хэлсэн хүмүүсийн санал дүгнэлтээс үзвэл тус аймгийн хөдөлмөрчид энэ жил хатас сая илүү төл бойжуулж, малын зүй бус хорогдлыг өнгөрсөн оны мөн үеийнхээс 36,3 хувь багасгаснаар мал өсгөх хөдөлшгүй төлөвлөгөөг биелүүлэх боломж урьдчилсан тооцоогоор харагдаж байна.

Гэвч энэ боломжтой байдал санаа амран тайвширч болохгүйн гадна жил бүрийн IV улиралд малын

элдэв хорогдол, зарлага үлэмж хэмжээгээр гардгийг зөвлөлгөөнөөс онцлон анхааруулаад энэ оны эхний хоёр улиралд хорогдсоноос илүү хэмжээний мал III улиралд хорогдсон явдалд дүгнэлт хийж ажиллах ёстойг заалаа.

Саяхан явагдсан мал тооллогын дүнгээс үзэхэд бод мал түүний дотор үхэр сүрэг өсөх нөөц багатайн дээр зохион байгуулалт хяналт, шалгалт, хариуцлага сулаас мал зүй бусаар хорогдож байгаа ноцтой дутагдал илэрчээ. Ялангуяа малын эмч нарын хариуцлага, шаардлагаас ихээхэн хоцорч байгааг үг хэлсэн олон хүн шүүмжлэн ярилаа.

Баянжаргалан сумын мал эмнэлэг (их эмч нь Бат-очир) халдварт дотрын хордлогоос сэргийлэх тарилгыг зохих цагт нь хийлгүй цаг алдуулж байгаад 400 гаруй мал уг өвчнөөр үхсний дараа тарианг хийсэн байна.

Түүгээрч барахгүй зарим малчдын хариуцлагагүй ажиллагаанаас болж нийгмийн мал сүрэг хорогдсон баримт цөөнгүй

гарчээ.

Баян-өнжүүл сумын Хоовон, Эрдэнэ сумын Гунгааш, Цэдэндамбаа нар 50—90 адуу дутаасны дээр Баянзүрх сумын тэмээчин Бааст нэгдлийн 25 тэмээ дутагдуулж, дээр нь өөртөө харнуцуулсан алдуу 30 тэмээг алдсан байна.

Нийгмийн социалист эмчийг ийнхүү үрэгдүүлэгчидтэй шийдвэртэй тэмцэл хийж, буруутай этгээдэд зохих хариуцлагыг хүлээлгэж улсыг хохиролгүй болговол зохино. Одоогийн байдлаар Баянжаргалан, Заамар, Лүн, Эрдэнэ, Эрдэнэсүм сумд тус бүр 2000 гаруй малыг зүй бусаар хороосон нь бусад сумдаас хорогдсон малын тоогоор илүү байна.

Түүнчилэн нилээд сумд малын орлого зарлагын тооцоог нөөц боломжоогоо дайчилж нарийн хийж чадаагүйгээс аймгийн онцгой даалгаврыг дүүрэн биелүүлж чадахааргүй тооцоо гаргажээ.

Энэ бүхнээс дүгнэлт хийж мал өсгөх улсын хуульчилсан төлөвлөгөөг хангаж биелүүлэхэд бүхий

л хүч бололцоогоо дайчлан ажиллах явдал тус аймгийн нам, улс, олон нийт, ХАА-н байгууллага малчдын нэн тэргүүний зорилт болж байна.

Зөвлөлгөөний анхаарал татсан чухал зүйл бол 1974 онд бойжуулж авсан хатас сая илүү төл малаа онд мөнд оруулах асуудал байлаа.

Нэг настай малыг зарим суманд 2000 толгойгоор суурилсны дээр нийт суманд эмчилгээ тэжээлийн цэг зохих ёсоор ажиллахгүй болсны улмаас өвчин эмгэгтэй хүч тарга муутай төл малыг одоо хүртэл эмчилж тэжээх ажил хийгдэхгүй байгаа дутагдлыг засч МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 32 дугаар тогтоолын заалтыг ширхэгчлэн биелүүлэх явдал шаардагдаж байна.

Мал өсгөх төлөвлөгөөг биелүүлэхийн улс төр эдийн засгийн ач холбогдлыг малчдад ухуулгын бүх хэлбэрээр тайлбарлан ойлгуулж, зохион байгуулалт хяналт шалгалтын ажил, социалист уралдааныг энэ ажилд чиглүүлж үйлдвэрлэлийн нэгж бүрт

нам улсын хариуцлага сахилга батыг өндөржүүлэх нь чухал байна.

Малаж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг яаравчлан хангах нь тулгарсан зорилт мөн.

Юуны өмнө малын хашаа худгийг засварлаж дулаалах, хэрэв ховхлон өвөлжөө бууцыг хатаах, өвс тэжээлийг татаж хамгаалах ажлыг шуурхайлан өвөлжилтийн хөдөлмөр зохион байгуулалтыг сайн хийж өвөлжих зураглал гаргах, адууг оторт гаргаж, бог малын бэлчээрийг адуунаас чөлөөлж өгөх шаардлагатай байна.

Эдгээр ажлыг гүйцэтгэсний үндсэн дээр 10 дугаар сарын 20-нд сууриудаас өвлийн бэлтгэлийг хүлээж авахаар шийдвэрлэв.

Малын зүй бус хорогдлыг багасгах талаар нам засгийн удаа дараагийн тогтоол шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэн 1974 оны мал өсгөх төлөвлөгөөг биелүүлж, малаа тарган тавтай онд бүрэн мөнд оруулах явдал манай аймгийн нийт хөдөлмөрчдийн чухал зорилт болж байна. Д. ТОВУУ

Сум, хот, хороод, үйлдвэр аж ахуйн газруудын 1974 оны социалист уралдааны дүн

Сумдын нэрс	1973 оны 3-р улирлын байр	1974 оны эхний хагас жилийн байр	1974 оны 3-р улирлын байр
Утаал	3	1	1
Борнуур	1	11	2
Эрдэнэсант	14	9	3
Сэргэлэн	16	5	4
Батсүмбэр	2	4	5
Баянзүрх	20	6	6
Баянцогт	4	13	7
Жаргалант	5	12	8
Баян-Өнжүүл	10	2	9
Баяндэлгэр	7	7	10
Дэлгэрхаан	19	8	11
Баянцагаан	21	3	12
Баянчандмань	22	17	13
Баянжаргалан	12	15	14
Баян	18	10	15
Өндөрширээт	11	16	16
Мөнгөнморьт	13	14	17
Заамар	6	21	18
Алтанбулаг	9	18	19
Бүрэн	8	20	20
Зуунмод	23	23	21
Лүн	17	19	22
Эрдэнэ	15	22	23

1973 оны 3-р улиралд	1974 оны 3-р улиралд
1. Хүнсний үйлдвэр	1 1
2. Тээврийг удирдах газар	2 2
3. Хөвдөл үйлдвэр	3 3
4. Барилга контор	9 4
5. Эмийн сангуудыг удирдах газар	5 5
6. НААУ-ний газар	4 6
7. Холбооны газар	6 7
8. Ойн үйлдвэр	7 8
9. УААУ газар	8 9
10. Архустын ТАА	13 10
11. Эрдэнэсүм	14 11
12. Нэгдэл дундын үйлдвэр	— 12

БҮРТГЭЛ ТООЦООНЫ АЖЛЫН МЕХАНИКЖИЛТ

Нам, засгаас бүртгэл тооцооны нүсэр хөдөлмөрийг хөнгөвчлөх, түүний чанарыг сайжруулан шуурхай болгох талаар олон чухал арга хэмжээ авсаар байна.

Манай улсын бүртгэл тооцооны ажлын механикжилтын эх үүсвэр болсон Статистикийн Төв Газрын бүртгэлийн станц 1960 онд ширээний жижиг 10-аад машинтай 10 операторын орон тоотой байгуулагджээ. Одоо бүртгэлийн машинт станц 130 гаруй орон тоотой, 3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй 700 шахам мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Орчин үед нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн явцад буй болж байгаа мэдээллийн хэмжээ байнга өсч түүнийг цуглуулан авах, боловсруулах ажлыг иж бүрэн механикжуулан автоматжуулж байна.

Социалист аж ахуйг эрхлэн хөтлөх түүнийг удирдах арга зохион байгуулалтыг цаашид боловсруулж болгох, нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд нийгэм эдийн засаг шинжлэх ухаан техникийн мэдээлэл, төлөвлөгөөний олон хувилбарт тооцоог улам шуурхай оновчтой болгох явдал бүрч чухал шаардлагатай юм.

Саяхан манай оронд

тооцоолон бодох төв байгууллагдаад байна.

Тооцоолон бодох төв нь бүртгэл тооцооны нүсэр хөдөлмөрийг хөнгөвчлөн, орчин үеийн техник, электрон машинаар улс ардын аж ахуйн томоохон бүртгэл тооцооны ажлыг бодож боловсруулах төдийгүй төлөвлөлт удирдлагын системийг улам боловсруулж болгож байна.


Цаашид улсын мэдээллийн автоматжсан систем байгуулах асуудлыг боловсруулж байна.

Улсын мэдээллийн автоматжсан систем нь бүх төрлийн мэдээллийг дамжуулах боловсруулах хадгалах нэгдсэн систем юм.

Манай аймагт удахгүй мэдээлэл боловсруулах станц байгуулагдахад Энэ станц нь тооцоолон бодогч автомат нягтлан бодох фактурын машин, ширээний тооны машинуудаас бүрдэх ба ажиллагсад дундаар 20—30 хүнтэй байна.

Мэдээлэл боловсруулах станц нь аймгийн үйлдвэр албан газруудын төлөвлөлт эдийн засаг, статистикийн мэдээллийн боловсруулалт хийхээс гадна аймгийн төвийн үйлдвэр албан газруудын нягтлан бодох бүртгэлийн ажлыг хэсэгчлэн боловсруулах замаар үйлчлэх хүрээ нь цаашид улам өргөжих юм.

С. АМАРБАТ



ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудад ЭХУ-ын нийлүүлэх нефть өссөөр байна

Нефть дамжуулах "Найрамдал", хоолойн 2 дахь салаа байгуулагдаж байна. Энэ салаа ашиглалтанд орсноор Чехословак, Венгер, Польш, БНАГУ-д олон зуун сая тонн шингэн түлш нийлүүлнэ.

ЗУРАГ ДЭЭР:

Лотарице гол дээрх нефть дамжуулах "Найрамдал" хоолой.

БАЙГУУЛАГДСАНЫ 50 ЖИЛИЙН ОЙД

ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛС

10 дугаар сарын 14 бол ЗСБН Киргиз улс байгуулагдсаны баярын өдөр юм. Киргизийн Коммунист Нам 1925 онд 2,5 мянган гишүүдтэй байсан бол одоо анхан шатны 3733 байгууллага, 106 мянга гаруй гишүүдтэй болжээ. ЗСБН Киргиз улс 198,5 мянган хавтгай дөр вөлжин км нутаг, 3 сая 218,0 мянган хүн амтай юм. Тус Бүгд Найрамдах Улс нүүрс, нефть хий, полиметаллын болон төмрийн хүдэр зэрэг асар их байлагтай. Мал аж ахуйн хязгаар байсан Киргиз одоо аж үйлдвэрийн 100 гаруй салбарыг хөгжүүлж байна.

Тус бүгд найрамдах улсад машин, металл боловсруулах, цахилгаан эрчим хүч, барилгын материалын болон хөнгөн хүнсний аж үйлдвэр түргэн хурдацтай хөгжиж байна. Хувьсгалын өмнө бүтэн жилд үйлдвэрлэн гаргаж байсан бүтээгдэхүүнийг одоо 2 дөр хүрэхгүй хугацаанд үйлдвэрлэж байна. Аж үйлдвэрийн хэмжээ нь 1913 оныхоос 245 дахин өссөний дотор 1973 оныг 1940 онтой зэрэгцүүлбэл савхин (арьсан) гутал 53, торгон эдлэл 202, хөвөн цаасан эдлэл 1151, ноосон эдлэл 25 дахин өсчээ.

Киргиз улс 1940 онд 0,05 сая киловатт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж байсан бол энэ онд 4284 сая киловатт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж байна. ХАА-н нийт бүтээгдэхүүн хувьсгалын өмнөхөөс 6,2 дахин өсч 1973 онд 1 сая 255 мянган тонн үр тариа үйлдвэрлэсэн нь IX таван жилийн эцэст үйлдвэрлэх хэмжээнээс давжээ. Мөн техникийн ургамал голлон, хөвөн чихрийн манжин, тамхи зэрэг ургамалын талбай 1973 онд 1924 оныхоос 2,6 дахин, үүний дотор хөвөнгийнх 2,2 дахин ихэсчээ.

Услаж тариалдаг тариалангийн талбай 896 га-д хүрч Зөвлөлт засгийн жилүүдэд 29,0 мянган километр урт усалтын суваг байгуулагджээ. Киргизийн ХАА-д 40,0 мянган механикчид ажиллаж байгаа нь 1940 оныхоос 3,6 дахин их юм. ЗСБН Киргиз улс нарийн ноост хониороо бахархдаг бөгөөд ноос үйлдвэрлэлтээрээ ЗХУ-д тэргүүний байранд ордог. 1973 онд 30,6 мянган тонн ноос үйлдвэрлэжээ. IX таван жилийн төлөвлөгөөний шийдвэрлэх жил 1974 онд 4,4 миллиард киловатт цаг цахилгаан үйлд

вэрлэж, ХАА-н нийт бүтээгдэхүүн 1 миллиард 68 сая рубль хүрнэ. Таван жилийн тэртээ Киргизд сургуулийн насны 100 хүүхдийн дөнгөж дөрөв нь суралцаж, зуун хүний гурав нь дөнгөж уншиж бичдэг байсан бол одоо бүх ард түмэн бичигтэн болсон төдийгүй бүх төрлийн сургуульд 1 сая гаруй хүн буюу Киргизийн гурван хүний нэг нь хамарч байна.

Социалист Киргизийн эрдэм шинжилгээний байгууллагуудад 1300 гаруй эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж байгаагийн дотор шинжлэх ухааны доктор, дэд эрдэмтэн 500 гаруй ажиллаж байна.

Н. ХАНДСҮРЭН

ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ТАДЖИК УЛС

ЗСБН Таджик улс 1924 оны 10 дугаар сарын 14-нд байгуулагджээ. ЗСБН Таджик улс Дундад Азийн зүүн өмнөд хэсэгт 143,1 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутаг эзлэн оршдог бөгөөд нутгийнх нь 90 гаруй хувь нь уул юм. Тус улс 3 сая 282 мянган хүн амтай. Таджикийн Коммунист Нам 90 шахам мянган гишүүд, орлогч гишүүд, анхан шатны 4097 байгууллагатай. Зөвлөлт засгийн жилүүдэд тус бүгд найрамдах улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 500 гаруй дахин өсчээ.

Таджик улс хөвөн үйлдвэрлэж байсан цахилгаан эрчим хүчээс 6 гаруй дахин их юм. ЗСБН Таджик улс хөвөн үйлдвэрлэлтээр ЗХУ-д III байр эзлэж байгаагийн дээр хөвөн-волокна үйлдвэрлэлтээр хувьсгалын өмнөхтэй зэрэгцүүлбэл 24 дахин өсчээ. IX таван жилийн эцэст 3 жилд 2 сая 330 мянган тонн, 1973 онд 800 гаруй мянган тонн түүхийн хөвөн тус тус үйлдвэрлэжээ.

Түүхийн хөвөнгийн ургацаар ЗХУ-д I байр эзлэж байгаагийн дээр АНУ, Иран, Пакистан, Турк улсуудаас хол давжээ.

Таджикстаны ХАА нь өндөр бүтээлтэй техникээр тоноглогдож 22 мянга гаруй трактор, хөвөн хураагч 3,0 гаруй машин, мөн авто болон бусад машин техник 10 гаруй мянга ажиллаж байна.

Тус улсын ХАА-д хэрэглэж байгаа цахилгаан эрчим-хүч нь дайны өмнөхөөс бараг 100 дахин их болжээ.

Намаг хатаах, усжуулах талаар өргөн их ажил зохиогдож, услах сувгийн урт нь 20,0 гаруй мянган километр болж усалж тариалдаг

550 гаруй мянган га талбай эзэмшжээ.

Таджикийн үйлдвэрүүдэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дэлхийн 40 гаруй оронд гаргаж байна. Зөвхөн Ленинбадын торгоны комбинатын одоогийн үйлдвэрлэж байгаа бөс бараа нь хаант оросын үйлдвэрлэж байснаас их юм. Хувьсгалаас өмнө тус бүгд найрамдах улсын нутаг дэвсгэр дээр ердөө л хэдхэн сургууль байсан бөгөөд дээд дунд боловсролын нэг ч сургууль байгаагүй бол одоо ерөнхий боловсролын мянга, их дээд 8, тусгай мэргэжлийн 40 дунд сургууль, техник мэргэжлийн 55 сургуульд 46,0 мянган багш нар ажиллаж байна. Таджикийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн адил тэгш эрх эдлэж коммунизмыг амжилттай байгуулалцаж байгаа бөгөөд таван мянга гаруй эмэгтэйчүүд инженер, агрономч, зоо техникч, хүний эмчээр ажиллаж байна. ЗХУ-ын болон Таджик улсын дээд зөвлөлийн депутатаар зуу гаруй эмэгтэйчүүд, 10 гаруй мянган эмэгтэйчүүд орон нутгийн зөвлөлийн депутатаар сонгогджээ.

чин Чулуун гуай, залуу саальчин Дариймаа, Намжилмаа, Аюурзана нарын 11 саальчин шагналт байр эзлэв.

Тугалын баярт сумын Цэцэрлэгийн Долгор, Намжав нарын удирдсан бүлгийн хүүхдүүд «Тугалчид» гэсэн сэдэвт концерт тоглож тэргүүний саальчид хүүхдийн бүтээлээр альбом хийж дурсгав.

С. РЭГЭЭДМАЛ

АНД НӨХДИЙН УУЛЗАЛТ

Саяхан БНАГУ байгуулагдсаны 25 жилийн ойг тэмдэглэх баярын цуглаан аймгийн Хүнсний үйлдвэрт болов. Цуглааныг Хүнсний үйлдвэрийн дэргэдэх намын үүрийн нарийн бичгийн дарга С. Бумбуу нээв. Дараа нь БНАГУ-ын мэргэжилтэн Вернер тус үйлдвэрийн ажилчин албан хаагчдад баяр хүргэж үг хэллээ. Мөн Хүнсний үйлдвэрийн талхчин П. Янжмаа үг хэлэхдээ: ах дүү Гер-

маны мэргэжилтэн Вернер, Вэлли нар манай үйлдвэрт орчин үеийн цахилгаан тоогоо суурилуулж өгсөнд баярлаж байгаагаа илэрхийлээд БНАГУ-ын 25 жилийн ойг манай ард түмэн хамгийн баяр баясалгантай тэмдэглэж байна гэв.

Цуглааны дараа БНАГУ-ын нам, засгийн төлөөлөгчид манай оронд айлчилсан болон Төв аймгийн тухай кино гарав. МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

СПОРТ

Олон хоногийн уралдаан

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМ АУ-ыг тунхагласны 50 жилийн ойн нэрэмжит Монгол-Зөвлөлтийн дугуйчдын олон хоногийн уралдаан өнгөрсөн 9 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 6 хүртэл явагдлаа. Энэ уралдаанд ЗХУ-ын Иркутск мужийн 12 тамирчны бүрэлдэхүүнтэй 2 баг, БНМАУ-ын 12 тамирчны бүрэлдэхүүнтэй 2 баг, бүгд 24 тамирчид, Иркутскээс Улаанбаатар хот хүртэл 1100 км уралдлаа. Уралдааны 7 дахь бариа нь Баруун Хараагаас Баянчандманий замд 80 гаруй км-т, тус аймгийн нэрэмжит болж явагдав. Уралдаанд ЗХУ-ын Иркутск мужийн тамир-

чин, ЗСБНХУ-ын аварга, олон улсын мастер Л. Очерин, Л. Яковенко, Д. Донский нар эхний 3 байрт оров. Тэргүүн байранд орсон тамирчдыг биеийн тамир спортын «Ургац» нийгэмлэгийн 1-3 дугаар зэргийн диплом, мөнгөн шагналар шагнав.

Энэ уралдаан тэмцээн жил бүр хоёр орны хооронд уламжлал болон явагдах юм. Энэ уралдаан тэмцээнийхнийг хүлээн авах ажлыг Баянчандманий нам, захиргаа, олон нийтийн байгууллагууд, Монгол Зөвлөлтийн найрамдлын сарын ажлын нээлттэй холбож сайн зохион байгууллаа.

Ж. ДАГВА

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ

ЗАРЛАЛ

Бүрэн сумын харъяат Жамбал овогтой Ханд, Баяндэлгэр сумын харъяат Дүгэр овогтой Энхээ нар иргэний 328959, 642213 номерийн үнэмлэхээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

ТУГАЛЫН БАЯР

Бүрэн сумын Ж. Самбуугийн нэрэмжит Бүрэн дэлгэрэх нээдлийн зөвлөл саахан сүүн тасагтаа Тугалын баяр хийлгэж 1974 оны сүү тосны үйлдвэрлэлийн дүнг хэлэлцэв.

Тус сум-нэгдэл 1974 онд сүү, цөцгийн тосны төлөвлөгөөг 100 хувь биедүүлсэн бөгөөд нэг нас-

тай малыг онд оруулах тухай МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг биелүүлэхтэй холбогдуулж тугалыг эхтэй нь 15 хоног, бэлчээрээр тэвээрлүүлэхээр шийдлээ.

Тугалын баяраар саальчин цуваа уралдааны дүнг гаргахад 70 настай сааль-